



Шинжээчийн үнэтэний тайлан

Байгууллагын нэр: **Эрдэнэт Цогцолбор Дээд Сургууль**

Хөтөлбөрийн нэр: **Ашигт малтмалын баяжуулалтын технологи**

Индекс: **072404**

Шинжээчийн баг:

Ахлагч: **С.Долгорсүрэн**

Гишүүд: **Э.Нацагдорж**

Н.Уртнасан

Он сар өдөр: 2024-02-06

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

-

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Эрдэнэт Цогцолбор Дээд Сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Ашигт Малтмалын Баяжуулалтын Технологи	
Индекс	072404	
Шинжээчид	<p>С.Долгорсүрэн – Техник Технологийн Дээд Сургуулийн Авто зам, материал судлалын тэнхимийн эрхлэгч МУ-ын зөвлөх инженер, профессор</p> <p>Э.Нацагдорж – Үндэсний Батлан Хамгаалах Их Сургууль Эрдмийн сургуулийн захирал доктор</p> <p>Н.Уртнасан – Монгол улсын зөвлөх инженер, доктор</p>	
БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунцэцэг	
Төлөвлөгөө	2024.01.18	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2024.01. 22	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2024.01.22	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2024.01.25-26	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2024.02.06	Шинжээчийн баг зохицуулагчид шинжээчийн тайланг илгээх
		Магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
		Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Гуравдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Зорилго: Ашигт малтмалын баяжуулалтын техник, технологийг удирдан явуулж, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга барил эзэмшсэн, харилцааны өндөр соёлтой, хувь хүний болон мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, мэдлэг, чадвараа бие даан хөгжүүлж чаддаг, өөрийн мэдлэгийг бусдад түгээн дэлгэрүүлэх, инженерийн төсөл зохиох, туршилт, судалгааны ажил гүйцэтгэх чадвартай бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэж төлөвшүүлэхэд оршино

Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learning Outcomes): ЭЦДС-ийн алсын хараа, эрхэм зорилгын дагуу хөтөлбөрийн хүрэх үр дүн (PLO)-г “(1) мэргэжлийн мэдлэг сэтгэлгээ, (2) хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, хандлага, (3) хүмүүстэй харилцах, багаар ажиллах ур чадвар, (4) салбар болон нийгэмд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадвар” гэсэн 4 бүлэг 19 ур чадварыг боловсруулан хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives):

Мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэхийн тулд хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж хичээл бүрээр дэмжин ажиллаж байна.

Суралцах орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, лабораторийн орчны тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулан ажиллаж байна.

Удирдлага мэдээллийн системийг сургалтдаа ашиглаж, сургалтын алба, багш, оюутнуудын хоорондын харилцаанд мэдээллийг шуурхай хүргэж, нээлттэй ил тод байдлыг бий болгон ажиллаж байна.

- **Хөтөлбөрийн төгсөгчийн загвар:** “Ашигт малтмалын баяжуулалтын технологи” хөтөлбөр нь ашигт малтмалыг баяжуулах, ялгах зориулалт бүхий объектуудыг барьж байгуулах, ашиглахад шаардагдах инженерийн хангамжийн бүхий л асуудлуудыг зохион байгуулж, шийдвэрлэх, эрдэс түүхий эдийг баяжуулж, ашигт эрдсүүдийг ялган авч, ашиггүй ба хорт хольцуудыг зайлуулах технологи, эдгээр үйл явцыг удирдлагаар хангах, тасралтгүй сайжруулах замаар тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулагч байхаар төгсөгчийн загвараа тодорхойлжээ.

Сургалтын төлөвлөгөөний бүтэц:

Хичээлийн төрөл	Заавал судлах хичээл		Сонгон судлах хичээл		Нийт суд. хичээл	
	кредит	хувь	кредит	хувь	кредит	хувь
Ерөнхий суурь хичээл (30% хүртэл)	36	27,9	6	0,5	42	32,6

Мэргэжлийн суурь хичээл (25%)	29	22,5	6	0,5	35	27,1
Мэргэжлийн хичээл (45% багагүй)	46	35,7	6	0,5	52	40,0
Нийт дүн	111	86,0	18	1,5	129	100,0

- **Багшлах бүрэлдэхүүний нөөц, чадамж:** Хөтөлбөрийн нэгжийн хувьд зөвлөх багш -2, /Ж.Баатархүү, П.Оюунсүрэн нар 30 жил ажилласан/ 10 багш орон тоон дээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 1 тэнхимийн эрхлэгч, 6 багш үйлдвэрээсээ гэрээт багш албан тушаалд ажиллаж байна. Бүх багш нар магистр зэрэгтэй эндээс 4 багш нь ШУТИС-ийнхаа докторантурт суралцдаг байна. Мөн Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүн нь 4-13 жил хүртэл тогтвортой ажиллаж Япон, ОХУ, БНСУ, Украин зэрэг улсад мэргэжил дээшлүүлсэн.
- **Суралцагчдын тоо:** 77 оюутан суралцаж байна.
- **Төгсөгчдийн тоо:** Сүүлийн 5 жилийн хугацаанд тус хөтөлбөрөөр 104 суралцагч төгссөн байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

Ашигт малтмалын баяжуулалтын технологи хөтөлбөрийг боловсруулахдаа МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого баримт бичиг “Алсын хараа 2050”-д үндэслэн үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан сургалтанд оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн байдлаар боловсруулан хэрэгжүүлж байна.

Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах түүнчлэн түүхий эдийг боловсруулан нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэл /баяжуулалтын үйлдвэр/ байгуулсанаар үйлдвэрлэлийг дагаад ашигт малтмалын баяжуулалтын технологийн инженер техникийн ажилчид нэн шаардлагатай байгааг Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд тулгуурлан судалгаатай гаргасан

Ижил төстэй сургалт явуулдаг дотоодын 2, гадаадын 1 сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулан өөрийн хөтөлбөрийн онцлог, давуу талуудыг гаргасан байна.

Онцлог зүйл:

Хөтөлбөрийн үндэслэлийн “Үндэсний түвшинд” хэсэгт дараах асуудлыг оруулах: Өнөөдөр Монгол улсын 3-4 Их дээд сургуульд “Ашигт малтмалын баяжуулалтын технологи” хөтөлбөрөөр оюутнууд сургахын зэрэгцээ ОХУ, БНХАУ болон Канад, Австрали зэрэг гадаадын сургуулиудад суралцан төгсөж, улмаар уул уурхайн салбарт ажиллаж байгаа хэдий ч төдийлөн хүрэлцээгүй байна. Нөгөөтэйгүүр ирээдүйд Монгол улсад эдийн засгийн эргэлтэд оруулахаар судлагдаж буй уул уурхайн ордуудад ажиллах инженерүүдийн хэрэгцээ маш их байгааг МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-д харуулсан байна. Иймээс “Эрдэнэт цогцолбор” ДС-ийн төгсөгчид нь зөвхөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн зориулалтын үйл хэрэгт төдийгүй олон улс, Монгол улсын уул уурхайн салбарт ажиллах мэргэжлийн хүчнийг бэлдэх бүрэн боломжтой, байна.

Анхаарах асуудал:

Сургалтын төлөвлөгөөг хийхдээ дотоод гадаадын ижил төстэй сургалт явуулдаг дотоодын гадаадын сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулдаг байна. Цаашид эдгээр сургуулиудын хөтөлбөрийн тоог олшруулах.

Хөтөлбөрийг ШУТИС-ийн ГУУС-ийн хөтөлбөрийн хороогоор дамжуулан мөрддөг. Хөтөлбөрийг 100% өөрчлөн сайжруулах боломжгүй байдаг сул талтай байгаа тул цаашид үүнийг уян хатнаар шийдвэрлэх тал дээр түлхүү ажиллах.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Дотоод, гадаадын ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлэгч их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, түүний агуулга, бүтцийн харьцуулсан судалгааг сайжруулж, салбартаа тэргүүлэгч гадаадын их, дээд сургуулийн хөтөлбөрийн харьцуулсан судалгаа хийсний үндсэн дээр хөтөлбөрийн төлөвлөлтийг хийх
- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний шинэчлэлтийн талаар гарсан шийдвэрийг тэмдэглэж архивладаг байх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

“Ашигт малтмалын баяжуулалтын технологи” хөтөлбөрийн зорилго нь ЭЦДС-ийн болон Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050” хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тодорхойлсон байна.

Хөтөлбөрийн зорилго, зорилт, төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар хандлагыг хэрхэн олгож буйд дүн шинжилгээ хийж оролцогч талуудаас хөтөлбөрийн (PLO) болон хичээлийн үр дүн (CLO) багшийн заах арга зүй, үнэлгээний систем, сургалтын орчны талаар судалгаа авч үр дүнд анализ хийж холбогдох арга хэмжээг төлөвлөн тасралтгүй сайжруулж хөгжүүлэлт хийсээр байна.

Онцлог зүйл:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын нэгж хэсгийн туршлагатай инженер, техникийн ажилтнуудын туршлага дээр тулгуурлан хөтөлбөрийн зорилго, зорилт, үр дүнг тогтмол сайжруулж, үйлдвэрлэлийн бааз суурь дээр тулгуурласан баяжуулалтын технологийн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах боломж нөхцөл бүрдсэн.

Анхаарах асуудал:

Хөтөлбөр хэрэгжүүлэхдээ хамтран ажилладаг байгууллага, аж ахуй нэгжүүд нь оюутнуудыг дадлага хийлгэх, ажлын байраар хангах, уулын баяжуулах үйлдвэрийн ИТА нар гэрээт багш хийх зэргээр хязгаарлагдаж байна. Өөрөөр хөтөлбөр боловсруулахад оролцож буй оролцоо харагдахгүй байгаа тул цаашид хөтөлбөр боловсруулахдаа хамтран ажилладаг байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог идэвхижүүлэх

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн сайжруулалт хийхэд ШУТИС, “Эрдэнэт үйлдвэр” – ийн дүрэм, журамд нийцүүлэх нь шат дамжлага ихтэй, хугацаа их шаарддаг тал ажиглагдсан тул Хөтөлбөрийн дэд хороо Чанар удирдлага мэдээллийн албатай хамтран шуурхай ажиллах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

БСШУ-ын сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу нийт хичээлийн ерөнхий суурь 30%, мэргэжлийн суурь 25%, мэргэшүүлэх хичээл 45% байхаар сургалтын төлөвлөгөөг боловсруулж хөтөлбөрийн үр дүн (PLO)-г тодорхойлж хүрэх үр дүн, залгамж холбоо, уялдаа хамаарлын дагуу төлөвлөсөн байна. Хөтөлбөрийн үр дүн (PLO) -д суурилан хичээлийн (CLO) суралцахуйн үр дүнгийн төлөвлөлтийг боловсруулахдаа хичээлийн агуулгын хүрэх үр дүн, залгамж холбооны матрицыг боловсруулан хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулж тусгаж өгсөн байна.

Онцлог зүйл:

Цаг үеийн хэрэгцээ шаардлага, боловсролын эрх зүйн өөрчлөлтөд нийцүүлэн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа түүний үндсэн хэсгүүдийн зохистой харьцааг хангах, оюутанд хичээл сонгон үзэх боломж олгох, оюутны ачааллыг зөвтөлөвлөх, оролцогч талуудын эрэлт хэрэгцээ, салбарын болон сургуулийн баримталж буй бодлого зэргийг тусгах бодлого барьж ирсэн.

Сургалтын үр дүн (PLO)-г ажил олгогчид, төгсөгчдийн судалгаанд үндэслэн багш нараар хэлэлцэн үр дүнд суурилсан хөтөлбөрийн мэдлэг, чадвар, хандлагын жагсаалтыг нийт 19 ур чадвар, 95 шалгуур үзүүлэлтээр тодорхойлон баталж, хичээл бүрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, өөрчлөх, сайжруулах явцад хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн саналыг тусгах оролцоог нь сайжруулах, турших, өөрчлөлтөд шинжилгээ хийх
- Төгсөгчдөөс авсан судалгаанд үндэслэн ямар мэдлэг, ур чадвар дутагдалтай байгааг судалж сургалтын төлөвлөгөөн дэх сонгон судлах хичээлд тусган оюутанд санал болгон оруулдаг байх

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Хөтөлбөрийн үр шимийг хүртэгч сонирхогч талуудыг тодорхойлж, сургалтын үр дүнг тандах оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч нэгтгэн дүгнэж байгаа нь сайн хэдий ч тухайн судалгаандаа тулгуурлан дүн шинжилгээ хийж төлөвлөдөг, богино хугацаанд тогтмол сайжруулалт хийдэг байх

ШАЛГУУР 1.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: *Бүрэн хангасан гэж үзэж байна.*

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын агуулгыг хөтөлбөрийн үр дүнтэй уялдуулан хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж хичээл бүрийн суралцахуйн үр дүнг нэгтгэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлсон байна.

Суралцагч нь суралцах явцдаа 2 удаагийн 3 хүртэл багц цагийн дадлагыг хамтран ажилладаг байгууллага, ах ахуйн нэгжтэй 3 талт гэрээний дагуу удирдагч багш, мэргэжилтнүүдийн удирдлага дор удирдамжийн хүрээнд нарийвчлан судалж гүйцэтгэлд тайлан бичиж хамгаалсанаар дадлагын үр дүн, авч буй үнэлгээ бодитой байх боломж бүрдсэн байна.

Сургалтын нэгдсэн Unimis системд хичээлүүдийн залгамж холбоог оруулсан

Онцлог зүйл:

Cloud Unimis смстемийг сургалтын үйл ажиллагаанд хэрэглэдэг

Анхаарах асуудал:

Оюутны сурах үйлд зарцуулж буй цаг нь дамжаа бүрд харилцан адилгүй ба I дамжаандаа хамгийн өндөр буюу 37кp ачаалалтай байгаа нь суралцагч өдөрт 11,2 цаг суралцах үйлд зарцуулахаар байна. Ачаалал нь II дамжаанаас буурч хэвийн түвшинд хүрч байна.

Үнэлгээ: *Бүрэн хангасан*

Зөвлөмж:

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн үр дүн хоорондын хамаарлыг уялдуулах

Сургалтын төлөвлөгөөнд ачааллыг жигд хуваарилахад анхаарч сайжруулалт хийх

2.2. Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

CDIO үр дүнд суурилсан сургалтын арга зүйг сургалтанд хэрэглэж сургалтын төрөл бүрийн арга хэрэглэдэг ба Блүүмын таксономын аргыг түлхүү хэрэглэж багш сургалтандаа асуудалд суурилсан арга, ганцаарчилсан болон баг болгон хуваах аргыг түлхүү хэрэглэдэг

Сургалтын үйл ажиллагаанд интерактив болон оюуны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх идэвхитэй аргууд (төсөлт хичээл, багаар ажиллах, ажил хэргийн тоглоом, хэлэлцүүлэг, дасгал, IT-мэдээлэл харилцааны технологи ашиглах) зэрэг аргуудыг өргөн хэрэглэхийн зэрэгцээ оюутнуудыг нийгэмшүүлж, төлөвшүүлэх, хөгжүүлэхэд чиглүүлж байна.

Онцлог зүйл:

ЭЦДС нь ШУТИС-ийн Cloud Unimis системийг сургалтын үйл ажиллагаанд хэрэглэдэг. Unimis систем нь нууцлал бүхий нэвтрэх эрхтэй, файлаар даалгавар авч, өгдөг, олон хувилбарт тест оруулах, хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг олон давуу талтай. Системийн тусламжтайгаар суралцагч тухайн улиралд суралцах боломжтой хичээлээс урьдчилан сонголт хийх, сонголтыг баталгаажуулах гэсэн дарааллаар явагддаг.

ЭЦДС нь ЭҮТӨҮГ-ын бүрэлдэхүүний нэгж болохын хувьд үйлдвэрийн бүхий л цех, хэсэгтэй хамтран ажиллах, суралцагчид дадлага, практикийг үр дүнтэй хийх боломж бүрдсэн. Сургалтын төлөвлөгөөнд тусгасан үйлдвэрлэлийн дадлага, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн практик дадлагыг ЭҮТӨҮГ-ын цех хэсгүүдэд хийх, практик хичээлийг инженер техникийн ажилтнууд удирдах, суралцагчид хөтөлбөрийн үр дүнг бодитой эзэмшин дадлагажих боломжтой.

Анхаарах асуудал:

Хөтөлбөрөөр суралцагчид мэргэжлийн хичээлийг 2 хүртэл багшаас сонголт хийж судалж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

Мэргэшүүлэх хичээл заах мэргэжлийн багш нарын хүрэлцээг нэмэгдүүлж хөтөлбөрөөр суралцагчидад багшийг сонгох боломжийг хүртээмжтэй болгох.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Суралцагчийн үнэлгээ нь сургалтын хөтөлбөрт хүрэхээр төлөвлөсөн мэдлэг, чадвар, дадал, ерөнхий болон мэргэжлийн ур чадвар, цогц чадамжийг үнэлэхэд чиглэсэн оюутны эзэмшихээр сурч буй хөтөлбөрийн ажлын байрны нөхцөлд тохирсон мэргэжлийн чиг баримжаатай байна.

Хичээл тус бүрт 100 онооны системээр үнэлж оюутны хичээлийн оролцооноос хамаарч багш оюутны хичээлийн ирц, явц, сорилууд, бие даалт, лабораторийн ажил зэрэгт 70 хүртэл оноогоор үнэлдэг бол улирлын шалгалтыг эгэл ойлголтууд 20%, үндсэн хэсэг 50%, асуудал шийдвэрлэх 30% гэсэн 3 хэсгээс бүрдсэн 30 хүртэл оноогоор үнэлж байна.

Онцлог зүйл:

2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улирлаас эхлэн оюутныг үнэлэх үнэлгээний задаргаанд явцын үнэлгээнд өөрчлөлт орсон байна. Үүнд суралцагчийг үнэлж буй байдал улам нарийвчлагдан үндэслэлтэй болсноор суралцагч өөрийн үнэлгээ хийх боломжтой болсон байна.

Анхаарах асуудал:

Хөтөлбөрийн онцлогт тохируулан үнэлгээ хийх арга сонгох
Рубрикийн аргыг ашиглан хэрхэн үнэлсэнээ тусгаагүй

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Үнэлгээнд рубрикийн аргыг яаж ашиглаж суралцагчдыг үнэлсэнээ хүснэгтээр оруулж өгөх

Сургалтын идэвхтэй аргад суралцах, судлах, турших

ШАЛГУУР 2.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан гэж үзэж байна.

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн ӨҮТ;

ХАБЭА-н иж бүрэн үзлэг, шалгалтын үр дүнгээр авах арга хэмжээний тухай ЭЦДС-ийн захирлын тушаалууд;

ЭЦДС-д 2023 оны 9 дүгээр сарын 11-14-ний өдрүүдэд явагдсан ХАБЭА-н 4 дүгээр шатны иж бүрэн хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөөө;

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ХАБЭА-н хэлтсийн албан шаардлагууд;

Итгэмжлэгдсэн лабораториудын сорилын дүн.

Онцлог зүйл:

Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа нь ЗХУ-ын Барилгын эрдэм шинжилгээ, зураг төслийн институтийн зураг төслийн даг уу баригдаж, 1975 онд ашиглалтад орсон өөрийн өмчлөлийн хичээлийн байранд явагддаг.

Хөдөө орон нутгаас суралцаж буй оюутнуудын сурч, амьдрах таатай орчныг бүрдүүлсэн, стандартын шаардлага хангасан оюутны дотуур байртай.

Эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан, мультимедиа /компьютер, проектор, ухаалаг самбар, дэлгэц зэрэг/ техник хэрэгслээр 100% хангагдсан, орчин үеийн интерактив сургалтын аргыг ашиглах боломж бүрдсэн хичээлийн анги танхимтай. Иж бүрэн тоноглогдсон сургалтын 12 лабораторитой.

Сургалтын үйл ажиллагаа, сургалтын орчинд тавигдах ХАБЭА-н шаардлагыг боловсруулан мөрдөж, зөрчигдсэн тохиолдолд авах арга хэмжээг шуурхай төлөвлөн ажилладаг.

Мэргэжлийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг таниулах загвар, моделиуд бүхий “Аюулыг таниулах төв”-ийг 2017 онд байгуулан сургалтад ашиглаж байна.

120-150 оюутны суудал бүхий шинжлэх ухаан технологийн сангийн уншлагын 2 танхимтай.

Анхаарах асуудал:

Суралцагчдад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ байхгүй.

Тусгай хэрэгцээт суралцагчдад зориулсан сургалтын орчныг бүрдүүлээгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Тусгай хэрэгцээт суралцагчдад зориулсан сургалтын орчныг бүрдүүлэх;

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх өрөө, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх бодит арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байх /орон тооны эмчтэй байх буюу биеийн тамирын багш эрүүл мэндийн сургалтад сууж анхан шатны мэдлэгтэй байх/

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа, хичээлийн жилүүдээр;

Суралцагчидтай хийсэн уулзалт;

ЭЦДС-ийн цахим сургалттай холбоотой судалгааны нэгтгэл, 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирал;

Багшийн ажлын тайлан, хичээл жил бүрээр.

Онцлог зүйл:

Онлайн сорил, шалгалтыг Google-Forms-д, цахим хичээлийг Open-edx платформд тус тус байршуулан цахим материалыг суралцагчид ашиглах боломжоор бүрэн хангасан.

2009 онд ШУТИС, ЭҮТӨҮГ, ЭЦДС-ийн хооронд Зайн сургалт явуулах иж бүрдэл тоног төхөөрөмж бүхий танхимыг байгуулан ашиглаж байгаа.

Оюутнуудад хэрэглээний программ хангамжуудыг эзэмшүүлэх, виртуал хичээл заах, төслийн ажил гүйцэтгэхэд зориулсан 75 компьютер бүхий 3 виртуал лабораторитой.

Лекцийн бүх анги, танхимыг орчин үеийн мультимедиа техник хэрэгслээрээ /LCD/DLP проектор, дэлгэц зэрэг/ бүрэн тоноглогсон болно

2020 оноос Open edx программыг ашиглан сургалтыг цахим, танхим хосолсон хэлбэрээр явуулж, улирал бүр үр дүнг гарган сайжруулах ажлуудыг хийж байна.

ЭЦДС-ийн багш бүр улирлын төгсгөлд тухайн улиралд заасан хичээлийнхээ бүлэг сэдвийн агуулга, даалгаврын сан, тоног төхөөрөмж, ном сурах бичгийн хэрэглээ, хэрэглэгдэхүүний тохирц, гүйцэтгэл, хэрэгжилтийг тайлагнадаг.

Анхаарах асуудал:

- УУМТТ мэргэжлийн программ хангамж бүхий компьютерийн хүрэлцээ, хангамж муу.
- Интернетийн хурд, сургалтад ашиглаж буй компьютерийн хүчин чадал хангалтгүй, утасгүй сүлжээний хамрах хүрээ хязгаарлагдмал.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Сургуулийн орчны утасгүй интернетийн сүлжээний хүртээмжийг сайжруулах

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн ӨҮТ;

ЭЦДС-ийн захирлын 2021 оны 08 дугаар 26-ны өдрийн А\93 тоот тушаалын 11 дүгээр хавсралт, ЭЦДС-ийн номын сангийн журам;

Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, улирал бүрээр

Номын сангийн катологи

Онцлог зүйл:

<https://www.research4life.org/> олон улсын судлаачдын нэгдсэн сан,
<https://lib4u.online/?lib=must>, ШУТИС-ийн номын сангийн электрон каталог,

www.greenstone.eit.edu.mn “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн электрон каталоогоор дамжуулан судалгааны ажлууд болон сурах бичгийг ашиглах боломжтой.

Үүлэн технологид суурилсан номын сангийн автоматжуулалтын LIB4U программ, олон улсад ашигладаг номын сангийн GREENSTONE программ, ШУТИС-ийн удирдлагын мэдээллийн UNIMIS системийн номын сангийн E-LIBRARY дэд программыг номын сангийн үйлчилгээнд ашигладаг.

Хөтөлбөрөөр суралцагсад нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдэд ашиглах ном, үндсэн сурах бичиг, нэмэлт гарын авлага, материалуудаар хангагдсан. Номын сангийн фондод шинжлэх ухааны бүх салбарыг хамарсан нийт 42533 ширхэг ном сурах бичиг байгаа ба номын фондыг жилд дунджаар 1000 гаруй шинэ номоор баяжуулан ашиглаж байна.

Нийтийн, эрдэм шинжилгээ болон тогтмол хэвлэлийн, оюутны байрны уншлагын танхим бүхий 280 м2 талбайтай номын сантай.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн ном, сурах бичгийн шинэчлэл хангалтгүй

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сүүлийн үед гарсан монгол хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгээр номын санг баяжуулах /мэргэжлийн ном сурах бичиг гадаад хэл дээр голдуу байна/

ШАЛГУУР 3.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

ЭЦДС нь БСШУ-ны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” 2022 оны 05-р сарын 09-ны өдрийн А/160 дугаар, ШУТИС-ийн дүрмийн 4.12, 10.2 дахь заалт, “ШУТИС-Ин Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу “Журам батлах, Хөтөлбөрийн хороо байгуулах тухай “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн захирлын 2014 оны 05-р сарын 14-ний өдрийн А/36 дугаар тушаалаар “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн Хөтөлбөрийн хороог байгуулан ажиллаж ирсэн байна.

“Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн Хөтөлбөрийн хорооны түр журам”-д Хөтөлбөрийн ерөнхий болон дэд хорооны бүтэц, үүрэг хариуцлага, оролцогч бүх талууд болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцож буй багш, ажилтан, оюутан, төгсөгчид болон хөдөлмөрийн зах зээлийн оролцоог тусгасан байна.

Онцлог зүйл:

Сургалтын хөтөлбөрийг инженерийн боловсролын шинэчлэлийн үр дүнд суурилсан сургалтын технологид нийцүүлэн өөрчлөхөөр төлөвлөн 2017 оноос хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр үндсэн болон гэрээт багш нарт нийт 52 удаагийн сургалтад оролцож, тус сургалтад Ашигт малтмалын баяжуулалтын технологи хөтөлбөрийн үндсэн 4, гэрээт 3 нийт 7 багш нар хамрагдаж, хөтөлбөрийн 48 хичээлийг үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн дагуу боловсруулсан байна. /Жнь: гидрометаллургийн чиглэлээр АМБоловсруулалтын технологи нэгж хичээлийг нэмэх

Багш нар нэгж хичээлийн төлөвлөгөө, хичээл тус бүрийн агуулгыг оюутнуудад хүргэхдээ танхим, цахим хослуулан ажилладаг бөгөөд ковидын үед google classroom, meet, form ашиглан цахим сургалтыг явуулж байсан бол 2020 оны хичээлийн жилээс Open edx платформыг цахим сургалтад ашиглаж эхэлсэн. /Энэ нь мэдээллийн технологийн хөгжилийг сургалтад цахим, танхим хослуулан явуулж байгаа нь идэвхтэй сургалтын аргуудыг нэвтрүүлж өөрийн онцлогтоо тохируулан ашиглаж эхэлж байгаас харагдаж байна. /

Анхаарах асуудал:

ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Суралцахуйн шинэчлэл ба карьер хөгжил” бүлэгт тулгуурлан Тус сургуулийг 2014-2024 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж байгаа ч хэрэгжилт, үнэлгээ хийсэн үр дүнг хөтөлбөртөө тусгах

Хөтөлбөрт үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр арга зүйг бүхэлд хэрэглэх биш өөрсдийн онцлогт тохируулан төгсөгчдийн загвартаа тааруулан сонгон хэрэгжүүлэх, мөн тодорхой хугацаатай турших ажлыг зохион байгуулах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөртэй холбоотой хийгдэж байгаа судалгаа, шинжилгээ үр дүнг тодорхой гаргаж хөтөлбөрийн зорилготой уялдуулах
- Хөтөлбөрөөс хүлээж байгаа үр дүнгээ тодорхой болгох, явцыг нь төлөвлөх, тайлагнах, мөн шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг болох
- Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг түвшин түвшингээр /сургалтын алба, тэнхим, багш/ нь төлөвлөж хийгдэх ажлуудыг тодорхой гаргах, мөн үнэлгээ хийх замаар сайжруулалтаа бий болгох.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд жил бүр дотоодын их дээд, сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хамтарсан төсөл, судалгааны ажил хийх, хамтарсан хөтөлбөрт оюутан, багш, судлаачдыг оролцуулах, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах, оюутны дадлагын ажил хийлгэх зэргээр хамтран ажиллаж байна. /Жнь: 2021-2023 онд “Багшийн судалгааны чадавхыг хөгжүүлэх сургалт”-д тус сургуулийн 49 багш ажилтан хамрагдсан.

Мөн оюутнууд тус сургуулийн захирлын тушаалаар Үйлдвэртэй танилцах болон Үйлдвэрлэлийн дадлагуудыг хийдэг бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд АМБТ хөтөлбөрөөр 90 гаруй суралцагчид дадлагаа хийсэн байна./

Мөн Булган аймгийн засаг даргын тамгийн газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд АМБТ хөтөлбөрөөр суралцагч нарыг /Л.Ариунжаргал, Ц.Мандах нарын 8 оюутныг/ 2 хичээлийн жил дараалан сургалтын төлбөрийг 50%-иар хөнгөлж дэмжлэг үзүүлсэн байна.

ХБНГУ-ын ADRIANA консорциум, G.E.O.S ХХК хамтран “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйд хуримтлагдсан хаягдал, ядуу агуулгатай хүдрийн овоолгыг дахин ашиглах, агаараас тандан судлах эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2023 оны 4-р сард Япон улсын Акита мужийн их сургуультай оюутан солилцооны чиглэлээр АМБТ хөтөлбөрийн 2-р курсын оюутан Б.Ган-Эрдэнэ 2023 ны 07 сард Акита мужийн их сургуульд сургалтын дадлага хийсэн.

Онцлог зүйл:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд 2021 онд “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ ашиглагдсан моторын тосыг хэрэглэн хамтын үндсэн флотацийн циклд молибден авалтыг нэмэгдүүлэх боломжийн судалгаа”, “Молибдены циклд Nash урвалжийг хэрэглэн молибден авалтыг нэмэгдүүлэх судалгаа”, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 8А болон 12 дугаар овоолгын хүдрийн колонкын уусгалтын туршилт судалгаа”, “Ил уурхайн шүүрлийн усны шинж чанар технологийн процесст нөлөөлөх нөлөөллийн судалгаа”-г зэрэг судалгаа болон төлийн ажилд тус хөтөлбөрийн багш нар /Ж.Батбаатар, Ж.Эрдэнэзул, Б.Билгүүн, Б.Алтансолонго/ оролцож, зохион байгуулж хийж гүйцэтгэсэн байна.

АМБТ хөтөлбөрөөр төгсөгчид “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т ажиллах эрх бүхий “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т ажиллах БАТЛАМЖ - г тус хөтөлбөрийн 12 төгсөгч хүртээд байна.

Анхаарах асуудал:

Хамтын ажиллагааны хүрээнд санамж бичиг, хамтын гэрээний төдий биш түүнд тусгагдсан ажил үүргийн дагуу хийгдэх ажлуудыг төлөвлөгөөтэй хийж гүйцэтгэх, үр дүнг тооцож ажиллах

Төгсөгчдтэй эргэх холбоотой ажиллах, давтан, мэргэшсэн сургалтуудыг зохион байгуулах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчдтэй эргэх холбоотой хамтарч тодорхой үйл ажиллагаа зохион байгуулдаг болох, цаашид сургах, мэргэшүүлэх тал дээр ажиллах
- Хамтарч ажиллаж байгаа байгууллагуудтай багш оюутан солилцоо болон бусад үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам боловсруулж ажиллах, мөн төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

Сургуулийн хувьд сургалтын болон эрдэм шинжилгээний үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй шинэчлэх үйл ажиллагаа; суралцагчид, нийгэмд чиглэсэн үйлчилгээ зэрэг үндсэн үйл ажиллагаанууд (үндсэн процессууд); хүний, материаллаг, технологийн нөөц зэрэг туслах үйл ажиллагаанууд (туслах процессууд)-ыг тогтвортой явуулах, өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн нөөцийг бүрдүүлсэн.

Сургалтын төлбөрийг жил бүр хичээлийн жилийн эхэнд инфляц, судалгаанд суурилан Удирдах зөвлөлөөр батлуулан уг батлуулсан төлбөрийг үндэслэн суралцагчдад мэдээллэдэг. 2018-2022 оны хичээлийн жилийн хугацаанд сургалтын төлбөрийн хэмжээнд өөрчлөлт ороогүй бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд 80,000төгрөг, 2023-2024 оны намрын улирлаас эхлэн сургалтын төлбөрийн 1кр-ийн үнэлгээг 111,000 төгрөг болгон өсгөсөн.

АМБТ хөтөлбөрийн зардлын задаргааг сургалттай холбоотой зардлын нийлбэрээр /9 үзүүлэлт багтсан/ Ковидын өмнөх үед өссөн боловч ковидын үед тогтворжуулсан байдлаар ба 2023 онд 38-42 хувиар өссөн хандлагатай байна. /туршилт дадлагад хэрэглэгдэх туслах материал, лаборатороор хийлгэсэн шинжилгээний зардал, /

Онцлог зүйл:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон бусад аж ахуй нэгж компаниудын жил бүр олгодог сургалтын тэтгэлэг, урамшуулалд АМБТ хөтөлбөрөөр суралцдаг оюутнуудаас жилд дунджаар 3-4 оюутан тогтмол хамрагдсан байгаа нь сурлагын чанар болон бусад үзүүлэлтэд сайнаар нөлөөлж байна. /Монгол XXI сан, Монголын зэс корпорацийн тэтгэлэг/

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Тус сургууль нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд үр дүнд суурилсан сургалтын идэвхтэй аргуудыг ашиглаж эхлэж байгаатай холбогдон суралцагчдын сурлагын чанар, тэдгээрийн хүрэх үр дүнд шаардлагатай төсөв, зардлыг төлөвлөгөөний дагуу тодорхой тусгаж өгөх

Тодорхой төлөвлөгөөтэйгээр суралцагчдийн тоог нэмэгдүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаар хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Тус сургууль нь сургалт судалгаа, олимпиад, эрдмийн баяр, урлаг спорт зэрэг ажлын явц үр дүнг олон нийтэд танилцуулан сурталчлах, байгууллагын нэр хүнд үйл ажиллагааг дотоод гадаадад хүргэх, хэрэглэгчийг татах зорилгоор нилээдгүй ажлуудыг хийж гүйцэтгэдэг байна. /Математик-байгалийн ухааны олимпиадыг зохион байгуулдаг ба 8-12-р ангийн 800 гаруй суралцагчид оролцдог. Үүний хажуугаар сургуулийн орчин, хөтөлбөрийн тухайн таилцуулж багшлах бүрэлдэхүүнүүд оролцдог байна./

Орон нутгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг танилцуулах, инженерийн болон нийгмийн ухааны чиглэлийн мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн онцлог, ач холбогдлыг сурталчлан таниулах зорилгоор жил бүр хөтөлбөрийн багш нар Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Дархан, Улаанбаатар хотуудад томилолтоор ажилладаг. /ЭЦДС-д элссэн нийт элсэгчийн 36.3%, АМБТ хөтөлбөрөөр элсэгчийн 41%-ийг орон нутгийн ЕБС төгсөгчид эзэлж байна/

Онцлог зүйл:

АМБТ хөтөлбөрийн багш нар хамтарсан төсөл, судалгааг зохион байгуулж удирдаж үр дүнг сургалтадаа нэвтэрүүлдэг. /ХБНГУ-ын ADRIANA консорциум, G.E.O.S ХХК , БНХАУ-ын BGRIMM TECHNOLOGY GROUP/

Анхаарах асуудал:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай идэвхтэй аргуудыг ашиглах үр дүнг тооцох, тандах судалгаа холбогдох материалыг боловсруулах, хэвших

Хөтөлбөрийг тогтворжуулах, идэвхжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй болох, хэрэгжилтийг үйл ажиллагааны тайландаа тусгаж ажиллах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Хөтөлбөрийг тогтвортой байлгахын тулд тодорхой асуудлуудыг /хөтөлбөрийн нэгж хичээлүүдийн суралцагчид өгөх мэдлэг ур чадвар, төгсөгчдийн загвар/ шингээсэн төлөвлөгөө гаргаж ажиллах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

Тус сургуулийн захирлын 2021 оны А/87 дугаар тушаалаар сургуулийн мэдээлэл харилцааны журмыг батлан мөрдөн ажиллаж байна. Тус журмын гуравдугаар бүлэгт мэдээлэл нь тодорхой, бодитой, үнэ цэнтэй, хариуцлагатай, эргэх холбоотой байна гэж заасны дагуу сургуулийн багш, ажилтан, оюутан, суралцагчдын талаарх албаны мэдээллийг Орхон аймаг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон өөрийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд нээлттэй, ил тод, шуурхай хүргэдэг юм байна. / Үүсгэн байгуулагч Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн “Өнөөгийн Эрдэнэт” сонин, Орхон аймгийн “Номин” телевиз, Тус сургуулийн танилцуулга, EIT PODCAST, мөн веб сайт www.erdenetis.edu.mn

Онцлог зүйл:

Тус сургуулийн үйл ажиллагааг таниулах, сургалт явуулдаг хөтөлбөрийн мэдээллийг хүргэх, мэргэжлийн онцлогийг таниулах, сурталчлах зорилгоор бэлтгэсэн мэдээ, мэдээллүүдийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын мэдээллийн технологийн хэлтсийн хөтөлөн явуулдаг “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ” фейсбүүк пэйж хуудас болон ФМ-ийн ярилцлагаар дамжуулдаг байна.

Анхаарах асуудал:

Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор веб сайтын мэдээллийг цаг тухай бүрд нь оруулдаг байх, суралцагчдын уралдаан тэмцээнд орох идэвх санаачилгыг дэмжих зэргээр үйл ажиллагаагаа сурталчлан таниулахад анхаарч ажиллах, мөн үр дүнг нь тооцож дүн шинжилгээ хийдэг болох

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Хөтөлбөрийг танилцуулсан сурталчлах ил тод болгох үүднээс хэдэн хэдэн төрлөөр бэлтгэх хэвлэх, мөн вебсайтын мэдээлэлийг байнга шинэчлэж өөрсдийн үйл ажиллагааг нээлттэй болгох, тогтмол ажиллуулах, үр дүнгээ тодорхой болгох

ШАЛГУУР 4.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан гэж үзэж байна.

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах заалт, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яамны сайдын 2013 оны 03 сарын 18-ны өдрийн А/79 дүгээр тушаал, 2016 оны А/87 дугаар тушаалын нэмэлт өөрчлөлт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлын 2021 оны 04 сарын 22-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”, “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль /ЭЦДС/-ийн дүрмийн 13.2, 13.4, 13.6, 13.8 дах заалтуудын дагуу жил бүр Ашигт малтмалын баяжуулалтын технологи мэргэжлээр элсүүлэхээр баталсан хяналтын тоог харгалзан элсэлтийг зохион байгуулдаг.

АМБТ хөтөлбөрөөр ерөнхий шалгалт өгөх суралцагч нь математик, физик эсвэл математик, хими хичээлүүдээр элсэлтийн шалгалт өгнө.

АМБТ хөтөлбөрөөр ерөнхий шалгалтын хичээлүүд ба босго оноо нь тухайн жилийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журмаар зохицуулагдана.

“Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн дэргэхэд Ахлах сургуулийн сурагчид, Мэргэжлийн боловсрол олгох сургалтад суралцагч нар тус сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт элсэхийг хүсвэл ЭЕШ-ыг математик, физик, хими, хичээлээр өгч болох ба нэг хичээл нь 400 түүнээс дээш оноо авсан тохиолдолд элсүүлэн суралцуулна.

Онцлог зүйл:

Математик, физик, химийн хичээл тус бүрээр элсэлтийн ерөнхий шалгалтад 750-аас дээш оноотой элсэгчдийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 100%, 700-749 оноотой бол 50%, 650-699 оноотой бол 30% хөнгөлнө. БШУЯ-наас тогтоосон олон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байр эзэлсэн элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 100% хөнгөлнө. Улс, бүсийн олимпиадад оролцсон элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 1-р байрт шалгарсан бол 100%, 2-р байрт шалгарсан бол 75%, 3-р байр /аймгийн олимпиадад 1-р байр/-т шалгарсан бол 50%, 4-р байр / аймгийн олимпиадад 2-р байр /-т шалгарсан бол 30%, 5-р байр /аймгийн олимпиадад 3-р байр/-т шалгарсан бол 15 хувь тус тус хөнгөлнө.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

“Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн сургалтын систем, хөтөлбөрийн онцлогийг таниулах, суралцах нөхцөл бололцоог хангах, оюутнуудыг дэмжин ажиллах, ёс зүйтэй төлөвшсөн иргэн болгон хүмүүжүүлэх зорилготой ажиллаж байна.

Зөвлөх багш оюутантай ажилласан хавтастай байх ба хавтаст оюутны анкет, төлбөр төлсөн мэдээ, ангийн хурлын тэмдэглэл, дүрэм, журам танилцуулга хийх эрх зүйн чиглэлээр зөвлөн гарын үсэг зурж баталгаажуулсан байдаг. Зөвлөх багш нь улирал бүр оюутан бүртэй сурлагын амжилтын талаар дүн шинжилгээ хийж, ирээдүйн ажил мэргэжил цаашид суралцах зорилгыг тодорхойлж өгдөг.

Оюутнуудын дунд хийсэн ярилцлагын үр дүнгээс харахад зөвлөх багш нар маш сайн ажилладаг.

Суралцагчдад зориулан бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн, /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог.

Анги тус бүрд зөвлөх багшийг томилон, оюутнуудыг сургалтын шинэ орчин нөхцөлд дасан зохицох сурах үйл ажиллагаагаа төлөвлөх, сургууль, тэнхимээс баримталж буй бодлого шийдвэрийг шуурхай хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд оролцогч багш оюутны уялдааг сайжруулах, оюутны суралцах үйлийг дэмжиж, хичээл сонголт болон амжилттай суралцахад зөвлөгөө өгч ажилладаг.

Онцлог зүйл:

2018-2019 оны хичээлийн жилээс “Мэргэжлийн удиртгал” хичээлийг шинээр сургалтын төлөвлөгөөнд нэмж оруулснаар, тэнхимийн эрхлэгч болон бусад мэргэжлийн багш нар оюутны элссэн мэргэжлийн талаарх суурь ойлголтуудыг өгдөг болсон.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Баяжуулалтын цехийн зөвлөх болон мэргэшсэн инженерүүд АМБТ-ийн хөтөлбөрийн оюутнуудад зөвлөгөө, цаашлаад гэрээт багшийн үйлчилгээ өгч байгаа нь онол практикийг хослуульж байна.

Суралцагчдад зориулан бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн, /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог.

“Эрдэнэт цогцолбор” дээд сургууль нь “Ашигт малтмалын баяжуулалтын технологи” хөтөлбөрөөр суралцаж буй оюутны эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаатай холбоотойгоор жил бүр зохион байгуулагддаг ба амжилт үзүүлсэн оюутнуудыг мөнгөн болон бусад шагналаар урамшуулан дэмжлэг үзүүлдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Эрдэнэт цогцолбор дээд сургуульд дараах мэргэжлийн болон сайн дурын клубүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд: Айсек клуб, Бэрсэн хүү, Багшийн туслах оюутан, Электроник автоматжуулалт клуб, Шийдэл илтгэх урлаг, мэтгэлцээний клуб, IT клуб.

2018-2023 онд АМБТ-ын оюутнуудын олон нийтийн ажилд оролцож манлайлсан, мөн тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан.

Оюутны сурлагын амжилт болон уралдаан тэмцээнд амжилт гаргасан буюу олон нийтийн арга хэмжээнд идэвх зүтгэлтэй оролцсон оюутнуудад Оюутны кредит урамшуулал олгох тухай тушаал, Оюутны кредит урамшууллын журам, Захирлын нэрэмжит тэтгэлэгт хамруулах журам-аар кредитийн урамшуулал олгодог.

Сургалтын төлбрийн хөнгөлөлтөд хамрагдсан оюутан /2022-2023/:

1. А.Давааням АМБТ-1 50%
2. Э.Нандинцэцэг АМБТ-1 30%
3. С.Оюундарь АМБТ-1 30%
4. Б.Өгөөмөр АМБТ-1 Монгол 21 сангийн тэтгэлэг
5. С.Энхсаруул АМБТ-1 Монгол 21 сангийн тэтгэлэг
6. Н.Энхтүвшин АМБТ-1 Төгсөгчдийн холбооны тэтгэлэг

Онцлог зүйл:

- Байхгүй

Анхаарах асуудал:

Оюутны холбоо болон оюутны зөвлөлөөс санаачлан зохион байгуулдаг нийгэмд үзүүлэх олон нийтийн, сайн дурын үйл ажиллагааг сайн дэмжин ажилладаг боловч нэг улиралд ноогдох ачаалал өндөр байдгаас оюутнууд олон нийтийн үйл ажиллагаанд оролцох идэвх сул байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:


1-р курсын ачааллыг тэнцвэржүүлэх, сургуулийн орчин, сургалт оюутны зөвлөлөөс зохион байгуулдаг ажлуудад идэвхитэй оролцох боломжийг бүрдүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт, хөдөлгөөнийг ШУТИС-ийн дүрэм журмын эмхэтгэлийн “Оюутны шилжилт хөдөлгөөний журам”-ын 2 болон 3 дахь заалтаар шийдвэрлэнэ.
- 2015-2022 онд нийт 25 оюутан шилжиж ирсэн, 25 оюутан шилжиж явсан байна.



Онцлог зүйл:

Оюутан, суралцагчдад монголын их, дээд сургуулиудын хооронд шилжин суралцах болоод өөр их, дээд сургуулийг төгссөн тохиолдолд тэдний аль нэг их, дээд сургуульд үзэж судалсан хичээлийн кредит болон авсан үнэлгээг дүйцүүлэн тооцоход “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захирлын 2021 оны 08 сарын 26-ны өдрийн А/399 тоот тушаалаар батлагдсан “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 7.2, 7.4-7.9 заалтуудыг баримталж ажиллана.

Шилжилт хөдөлгөөн харьцангуй бага байна.

Тайлант хугацаанд АМБТ хөтөлбөрт шилжиж ирсэн 6 суралцагчийн 83% нь ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиас, 17% нь дотоод бусад их, дээд сургуулиудаас ирсэн бөгөөд эдгээр суралцагчийн 20 хичээлийн 170 багц цагийг журмын дагуу дүйцүүлэлд хийж, оюутныг хохиролгүй үргэлжлүүлэн суралцах боломжоор хангаж ажилласан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 480 дугаар тушаалаар баталсан “Дээд боловсролын диплом олгох журам”, мөн сайдын 2012 оны “Боловсролын баримт

бичгийн загварыг шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тушаалаар төгсөлтийн баримт бичиг, энгэрийн тэмдэг олгоно.

Төгсөлтийн комиссыг үүсгэн байгуулагч Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн эрдмийн зэрэгтэй топ менежерүүд, ШУТИС-ийн болон Технологийн сургуулийн эрдэмтэн багш нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулдаг.

Онцлог зүйл:

ШУТИС Сурлагын голч 3.6 дээш бол ОНЦЛОХ дипломыг тусгай тэмдэглээтэйгээр олгож байна.

Бакалаврын сургалтыг “Онцлох” дипломтой төгссөн оюутанд Эрдэнэт үйлдвэр ХХК-д урилгаар ажиллах “БАТЛАМЖ”-ийг гардуулдаг болсон. Энэ “БАТЛАМЖ” –ийг нийт 64 оюутан гардан авч, Эрдэнэт үйлдвэр ХХК-д урилгаар ажилд орж, амжилттай ажиллаж байна.

Анхаарах асуудал:

Төгсөгчдийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтанд сургахад анхаарах

Үнэлгээ: Бүрэн хангасан.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн төгсөлтийн дараах сургалтын үйлчилгээг өргөжүүлэх.

ШАЛГУУР 5.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан гэж үзэж байна.

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

ЭЦДС-ийг 2014-2024 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд тусгагдсан хүний нөөцийн зорилтуудын хэрэгжилтийг хангаж байна.

Хүний нөөцийн талаар авч хэрэгжүүлэх бодлого чиглэл, зорилго зорилтуудыг бизнес төлөвлөгөөтэй нийцүүлэх үе шатанд: Тэнхимийн багш тус бүрээр багийн хэмжээнд үүсэж болох хэрэгцээ, өнөөгийн хангалтыг харьцуулан үзэж цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг салбар, тэнхимийн хурал дээр хэлэлцэн шийдвэрлэдэг. Багш тус бүрийн гаргасан саналыг нэгтгэн жил бүрийн үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөнд тусгах ажлыг салбарын эрхлэгч хариуцдаг. Үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөнд орох нэгтгэсэн саналуудыг Захирлын зөвлөлөөр эцэслэн хэлэлцэж шийдвэрлэж байна.

Одоогийн хөтөлбөрийн нэгжийн хувьд зөвлөх багш -2, /Ж.Баатархүү, П.Оюунсүрэн нар 30 жил ажилласан/ 10 багш орон тоон дээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 1 тэнхимийн эрхлэгч, 6 багш үйлдвэрээсээ гэрээт

багш албан тушаалд ажиллаж байна. Бүх багш нар магистр зэрэгтэй эндээс 4 багш нь ШУТИС-ийнхаа докторантурт суралцдаг байна. Мөн Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүн нь 4-13 жил хүртэл тогтвортой ажиллаж Япон, ОХУ, БНСУ, Украин зэрэг улсад мэргэжил дээшлүүлсэн.

Багш ажилтны цалин хөлс урамшууллын зорилтууд, ангилал, хэмжээ, ажлын үр дүнтэй уялдах байдал зэрэгт ШУТИС, ЭҮТӨҮГ-ын журмуудад үндэслэдэг. /Залуу гэр бүлд орон сууцны хөнгөлөлтөд 13,0 сая/

Онцлог зүйл:

АМБТ хөтөлбөрийн хичээлүүдийг мэргэжлийн багийн зохион байгуулалттайгаар төлөвлөгөө гаргаж, сургуулийн зөвлөх багш нартай зөвлөлдөж тасралтгүй сайжруулж хөгжүүлдэг. ЭЦДС-д үндсэн багшаас гадна үйлдвэрт ажилладаг инженерүүдийг гэрээт багшаар урьж хичээл заалгадаг нь онолын мэдлэгээс гадна практик чадварыг оюутнуудад зэмшүүлэх боломжийг олгож байна. Мөн хөтөлбөрийн инженер багш нар багшлах эрхийн 2017-2023 оны хооронд сургалтад суралцсан байна .

Мөн сургуулийн захирлын тушаалаар багшлах бүрэлдэхүүндээ урамшуулалыг олгодог байна.

Анхаарах асуудал:

Тус сургууль нь багшлах бүрэлдэхүүний зэрэглэл урамшуулал тооцоолох өөрийн сургуулийн онцлогтой тохирсон журамтай болох мөн /сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн чиглэлийн/ ачаалалаас хамааран урамшуулж тогтвортой байх боломжийг бүрдүүлж ажиллах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Багш нарын судалгааны ажлын үр дүнгээр нь судалгааны болон лабораторийн туршилтын зардлыг гүйцэтгэсэн ажлын тодорхой хувьтай дүйцүүлж сургуулиас санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, үр чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

ШУТИС-ийн захирлын 2021 оны А/243 тушаалаар “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг баримтлан чиглэсэн дараах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ирсэн байна. “ЦАХИМ СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ”, “ҮР ДҮНД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР”, “ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ” хэлэлцүүлэгт тус сургуулийн бие бүрэлдэхүүн оролцдог байна.

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

ЭЦДС-ийн багш нар эрх, үүргийнхээ дагуу эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь багш хөгжүүлэх бодлогыг “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-д нийцүүлэн

“ЭЦДС-ийн профессор, багш нарын ачааллыг төлөвлөх, гүйцэтгэлийг тооцох журам”, “ЭЦДС-ийн хүний хөгжлийн сургалтын журам”, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажилтны эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажилтан, оюутны тэтгэлэгт сургалтын журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд үндэслэн төлөвлөн ажилласан байна.

Анхаарах асуудал:

Тус сургуулийн багш, судлаачид орчин үеийн сургалтын арга, технологийг сургуульдаа хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдэд багшын оролцоо, идэвхийг сайжруулж багшлах бүрэлдэхүүний суралцах боломжийг ЭЦДС-ийн удирдлагын зүгээс анхаарч ажиллах /бие даах боломж/

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг бий болгох багшлах бүрэлдэхүүн болон мэргэжлийн шаардлага хангасан мэргэжилтэнг бий болгох, мөн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, сургалтыг зохион байгуулах

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Тус сургууль нь боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх, Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн таатай орчныг бүрдүүлэх талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах, үр дүнд болон чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэн ажилладаг.

Хөтөлбөрийн зорилго нь ЭҮТӨҮГ-ын, ШУТИС-ийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит ЭЦДС-ийг 2014-2024 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, ЭЦДС-ийг 2024-2034 онд хөгжүүлэх стратеги төлөвлөөг хэрэгжүүлэхэд багш нарын оруулж буй хувь нэмэр, гүйцэтгэсэн ажлын кредит хэмжээ, үр дүнг тодорхойлох, үнэлэх, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тус сургуулийн тэнхим багш, ажилтнууд 2017-2022 он дуустал нийт 47 төрлийн 4 байгууллагын захиалгаар 1,521,249.9 төгрөгийн төсөвтэй төсөл хөтөлбөрийг 4 тэнхимийн давхардсан тоогоор 124 багш ажилтнууд мэргэжлийн хүрээнд ЭҮТӨҮГ, олон улсын болон үндэсний үйлдвэр аж ахуй нэгжийн захиалгат төсөлт ажлуудыг амжилттай гүйцэтгэсэн байна.

Нийт төсөлт ажлын 47%-г Уул уурхайн тэнхим дангаараа гүйцэтгэсэн байна. УУТ-ын багш нарын хувьд 2018 – 2022 оны хооронд нийт 21 судалгааны ажил гүйцэтгэж 437,815 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн бол 2023 онд 345,000 төгрөгийн үнэлгээтэй 1 төсөлт судалгааны ажил гүйцэтгэж байна. Эдгээр судалгааны ажилтай холбоотой өгүүлэл, илтгэлийг хэлэлцүүлсэн байна.

Онцлог зүйл:

Хөтөлбөрийн үндсэн багш нараас 4 докторантурт суралцаж, судалгааны ажлаа холбогдох уул уурхайн салбаруудад туршилт, эрдэм шинжилгээний ажлыг хийж,

туршлагаа бататгаж байна. /Ш.Амгаланбаяр, Эрдэнэтийн овоо ордын чулуулгын шинж чанар, тэсэлгээний дараах бутлалтын үзүүлэлтүүд, 2021-2022/

Анхаарах асуудал:

Хөтөлбөрийн багш нар эрдэм шинжилгээний төсөлт ажил гүйцэтгэснээр заадаг хичээлийн агуулгад өөрчлөлт, сургалтын арга зүй, технологид шинэчлэл хийж байгааг хөтөлбөрийн баг болон сургуулийн удирдлагын анхаарч ажиллах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Төсөл болон судалгааны ажлын захиалга өгч байгаа байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, судалгаа болон шинжилгээг хийх төсөв болон эрх зүйн орчныг сайжруулах боломжийг судлаж ажиллах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

Багш нар хичээлийн хагас жил бүрд өөрийн хувь хүний хөгжлийн төлөвлөгөө болон үнэлгээний тайланг бичиж сургуулийн захиргаанд хүргүүлдэг. Мөн тэнхимдээ хичээлийн хөтөлбөрийн сэдвийн агуулга, даалгаврын сан, үнэлгээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэл, сайн туршлага агуулгаар бэлддэг.

Багшийн хөндлөнгийн үнэлгээг удирдлага, оюутнуудаас авах онлайн системийг “CLOUDUNIMIS” программыг хөгжүүлэн ашиглалтад оруулсан оюутны вебээр дамжуулан оюутнуудаар хичээл заасан багшийг үнэлүүлэх ажлыг гүйцэтгэж байна.

Онцлог зүйл:

Багшийн хавтасыг бүрдүүлж хэрэгжүүлж хянаж мөн зохион байгуулж хэвшсэн байна. Хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөр, лекц, семинар, бие даалт, сорил шалгалтыг агуулгыг багтаасан байна.

Анхаарах асуудал:

Багшлах бүрэлдэхүүний цаашид өсөн дэвших нөхцөл нь тэдгээрийг үнэн зөв бодитой системтэйгээр үнэлэх нь сургалтын орчин болон сургалтын чанарт нөлөөлдөг тул өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Тус хөтөлбөрт олон жил ажилласан багшлах бүрэлдэхүүн мэдлэг ур чадварыг тус хөтөлбөрийн багш нарт туршлага болгож тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөшүүрэг болгох, залуу багш нар нь өөрсдийгөө үнэлэх, дүгнэх, цаашид хийх арга хэмжээ, боловсруулах арга зам, боломжуудийг нээж өгөх

ШАЛГУУР 6.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: *Бүрэн хангасан гэж үзэж байна.*

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

ЭҮТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2018 оны 03 сарын 22-ны А/325 дугаар “ЭЦДС-ийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” тушаалаар “Эрдэнэт цогцолбор” дээд сургуульд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, хэрэглэгчийн шаардлагын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, Удирдах зөвлөл болон захиргааны зөвлөлийг удирдлагын мэдээллээр хангах, чанарын зорилтуудын биелэлтэд дүн шинжилгээ хийх, сургалтын хөтөлбөр болон байгууллагын магадлан итгэмжлэлтэй холбоотой дүн шинжилгээ хийж сургуулийн удирдлагын үйл ажиллагаанд дэмжлэг болгох” зорилготойгоор Чанар удирдлагын мэдээллийн алба /ЧУМА/ шинээр байгуулж, 2 чанарын мэргэжилтэн, 1 сүлжээний мэргэжилтэн, 1 программ зохиогч гэсэн 4 хүний бүрэлдэхүүнтэй сургуулийн захирлын шууд удирдлага дор ажиллаж байна.

ЭЦДС нь 2017 онд чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2016 нэвтрүүлсэн.

Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO21000:2021 нэвтрүүлсэн.

Багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож үнэлэх журамтай. 2021 оны 12 сарын 21-ны А/165 батлагдсан

Онцлог зүйл:

"Эрдэнэт цогцолбор" дээд сургууль нь дотоод аудиторуудаа чадавхжуулах зорилгоор Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2016 стандартын тэргүүлэх аудиторын сургалтыг 2019 оны 3 сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулсан. Эс Эф Си Эс ХХК-ийн баталгаажуулалтын аудиторт тавигдах шаардлагыг хангасан тус хөтөлбөрт хичээл ордог сургалтын албаны дарга Д.Болор-Эрдэнэ (Физик 1, Физик 2), Уул уурхайн тэнхимийн эрхлэгч Ж.Батбаатар (Баяжуулах процессын загварчлал, Баяжуулах үйлдвэрийн төсөл), ХАБЭА-н инженер Д.Лхагва (Гамшгаас хамгаалах менежмент), СШУТ-ийн багш С.Цээлэй(Ерөнхий хими, Органик хими, Физик коллоид хими), Б.Цэрэнханд (Философийн үндэс) нар тэргүүлэх аудиторын гэрчилгээ гардан авсан.

Анхаарах асуудал:

Түвшин тогтоох шалгалт авч үр дүнг нээлттэй мэдээлдэг хэмээжээ. Гэвч ямар хэлбэрээр хэрхэн авдаг нь тодорхой бус байна.

Үнэлгээ: *Бүрэн хангасан*

Зөвлөмж:

Түвшин тогтоох шалгалтын асуулт бусдад нээлттэй, шалгалт авах хэлбэр тодорхой байх тал дээр анхаарч ажиллах.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

ЧУМА нь 2018 оноос оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааг нарийвчлан хийдэг болсон ба 2018 онд нийт оюутнуудын 22,3% нь уг судалгаанд хамрагдаж байсан бол жил ирэх бүр өссөөр 2022 онд нийт оюутнуудын 72% нь хамрагдсан бол “Ашигт малтмалын баяжуулалтын технологи” хөтөлбөрийн хувьд судалгаанд оролцогч оюутнуудын идэвх сургуулийн дунджаас өндөр оролцож, сургуулийн сайжруулах тал дээр өөрсдийн дуу хоолойг хүргэдэг.

Хөтөлбөрийн сургалтаар олгож байгаа мэдлэг чадварыг хувьд 2018 онд 49,5% буюу оюутнууд сэтгэл ханамж бага байсан бол 2022 оны судалгаагаар 93,7% нь хангалттай мэдлэг, мэдээлэл өгч чаддаг гэж хариулсан нь төгсөгчид хөтөлбөрийн сайжруулалт сайжирхан түлхэц болсон байна.

Онцлог зүйл:

Төгсөгчийн загвараа зөв тодорхойлсон

2018 оноос эхлэн жил бүр тасралтгүй төгсөгчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч хэвшсэн

Сүүлийн 5 жилийн хугацаанд тус хөтөлбөрөөр 104 суралцагч төгссөн ба төгсөгчдийн ажил эрхлэлт уул уурхайн салбарт өндөр байгаа ба нийт төгсөгчдийн 51,58% нь Эрдэнэт үйлдвэрт, 15% нь Оюу толгойд, 14% нь МАК ажиллаж байгаа нь тус сургуулийн Ашигт малтмалын баяжуулалтын технологи хөтөлбөр нь уул уурхайн салбартаа эрэлт хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

Анхаарах асуудал:

Төгсөгчидтэй хийсэн ярилцлагад дийлэнх төгсөгчид ажлын байран дээр гарахдаа гадаад хэлний мэдлэг дутмаг, дата анализ хийх чадвар сул байсан гэж дүгнэж байсан.

Үнэлгээ: *Бүрэн хангасан***Зөвлөмж:**

Төгсөгчидийн ажлын байран дээр гарахдаа хийж байгаа дүгнэлтэд тулгуурлан хөтөлбөрөөр суралцагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлж, дата анализ чадварт суралцах тал дээр анхаар, хөтөлбөрт тусгаж ажиллах.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

“Эрдэнэт цогцолбор” дээд сургуульд сүүлийн 5 жилийн хугацаанд тус хөтөлбөрөөр 104 төгсөгч төгссөний 12 төгсөгч буюу 11,5% нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т ажиллах батламж гардан авсан нь хөтөлбөрийн чанарын үр дүнг тодорхой харуулж байгаа ба “Оюу толгой” ХХК-н захиалгаар 2018-2021 оны хооронд анхны ажлын байран дээр нь “Ашигт малтмалын баяжуулалтын технологи” хөтөлбөрийн бакалаврын эчнээ сургалтыг амжилттай зохион байгуулан 24 бакалаврын инженерийг бэлтгэн гаргасан.

Үе үеийн төгсөгчид нь нийслэл болон 21 аймгийн уул уурхайн салбар, засварын төв, замын цагдаагийн хэлтэс, цахилгаан шугам сүлжээ, зураг төслийн хэлтэс, ХАБЭА-н салбарт амжилттай ажиллаж байна. Үүнд 1999-2000 оны АМБТ мэргэжлийн төгсөгч Т.Батмөнх “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий инженер, 2001-2002 оны төгсөгч Г.Цогтгэрэл “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын Баяжуулах үйлдвэрийн ерөнхий инженерээр ажиллаж байгаа ба тус хөтөлбөрийн мэргэжлийн анхны багш нарын нэг П.Оюунсүрэн 2023 онд Монгол улсын “Гавьяат багш” болсон.

Онцлог зүйл:

Хөтөлбөрийн үнэлгээг улирал бүрийн эцэст оюутан, төгсөгч, хөтөлбөр хэрэгжүүлсэн багш нар, салбарын төрийн болон төрийн бус байгууллагаар тогтмол үнэлүүлэх үндсэн үүргийг хөтөлбөрийн удирдлага хүлээж жил бүр хэрэгжүүлж хэвшсэн.

Чанар удирдлага мэдээллийн албанаас 2019-2023 онуудад жил бүр дотоод аудит хийж үр дүнг бичгээр хүргүүлдэг.

Анхаарах асуудал:

Дан ганц Эрдэнэт үйлдвэртэй бус бусад том уул уурхайтай төсөл судалгаан дээр ажиллах, хамтрах боломжуудыг эрэлхийлэх

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

ЭЦДСургууль нь зөвхөн үйлдвэрийн харьяа гэдэг утгаараа Эрдэнэт үйлдвэр дээр хэрэгжүүлж буй төсөл, судалгаанд багш оюутнууд хамруулдаг нь өрөөсгөл байна. Уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж буй өнөө цагт Эрдэнэт үйлдвэртэй ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагуудын төсөл, судалгаанд оролцох боломжуудыг эрэлхийлж хамтран ажиллаж багш оюутнуудыг өргөнөөр хамруулах.

Шаардлага:

Чанар удирдлага мэдээллийн албанаас жил бүр хийдэг дотоод аудитын шалгуур шаардлагад ISO 9001, ISO21001 шалгуур шаардлагыг түлхүү оруулдаг байна. Шалгуур шаардлагад байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагаас оруулан үнэлгээг хийдэг байх

Дотоод аудитаар илэрсэн зөрчлүүдэд дүгнэлт хийж санал, зөвлөмжийг үндэслэн төлөвлөгөө гарган ажиллаж сайжруулалт хийдэг байх

ШАЛГУУР 7.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Ашигт малтмалын баяжуулалтын технологи хөтөлбөрийн хэрэгжилтэд магадлан итгэмжлэлийн шинжээчийн бүлэг ажиллаад доорхи 7 шалгуурын дагуу 6 шалгуур бүрэн хангасан, 7 дахь шалгуурын 7.1, 7.2 бүрэн хангаж 7.3 хэсэгчилэн хангасан буюу 7-р шалгуурын бүрэн хангасан гэж дүнгэсэн. Нийт үнэлгээгээр бүрэн хангасан гэж үнэлж байна.

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	3			Бүрэн хангасан
2 Сургалтын үйл ажиллагаа	3			Бүрэн хангасан
3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			Бүрэн хангасан
4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			Бүрэн хангасан
5 Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа	5			Бүрэн хангасан
6 Багшийн үйл ажиллагаа	4			Бүрэн хангасан
7 Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	1		Бүрэн хангасан
Дүгнэлт	Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

/Нэгдсэн зөвлөмжид дээрх зөвлөмж, шаардлагыг шууд тусгахгүйгээр агуулгыг нэгтгэн сургуулийн удирдлага, хөтөлбөрийн баг бодитой хэрэгжүүлж, үр дүнд хүрэх боломжтойгоор томъёолж боловсруулсан байна./

Шалгуур		Зөвлөмж
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> ▪ Дотоод, гадаадын ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлэгч их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, түүний агуулга, бүтцийн харьцуулсан судалгааг сайжруулж, салбартаа тэргүүлэгч гадаадын их, дээд сургуулийн хөтөлбөрийн харьцуулсан судалгаа хийсний үндсэн дээр хөтөлбөрийн төлөвлөлтийг хийх ▪ Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн шинэчлэл хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлсэн протокол, шийдвэрээ дэлгэрэнгүй бичих ▪ Хөтөлбөрийн үр шимийг хүртэгч сонирхогч талуудыг тодорхойлж, сургалтын үр дүнг тандах оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч нэгтгэн дүгнэж байгаа нь сайн хэдий ч тухайн судалгаандаа тулгуурлан богино хугацаанд тогтмол сайжруулалт хийдэг байх ▪ Хөтөлбөр хэрэгжүүлэхдээ хамтран ажилладаг байгууллага, аж ахуй нэгжүүд нь оюутнуудыг дадлага хийлгэх, ажлын байраар хангах, уулын баяжуулах үйлдвэрийн ИТА нар гэрээт багш хийх зэргээр хязгаарлагдаж байна. Өөрөөр хөтөлбөр боловсруулахад оролцож буй оролцоо харагдахгүй байгаа тул цаашид хөтөлбөр боловсруулахдаа хамтран ажилладаг байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог идэвхижүүлэх
2	Сургалтын ажиллагаа үйл	<ul style="list-style-type: none"> • Сургалтын төлөвлөгөөний матрицаас харахад нилээдгүй хичээл дээр багш өөрийн ордог хичээлээр 19 ур чадварыг бүрэн олгохоор төлөвлөсөн, оюутны 7 хоногийн цагийн ачаалал тооцохдоо лекц, семинар, лаборатори, бие даалтын цагийг хэт өндөр тооцсон байна. Иймээс эдгээрийг дахин нягтлах • Дадлагын талаар хамтран ажиллах гэрээт байгууллагын тоог нэмэгдүүлэх • Дадлагын үр дүнг хянаж, шинжилгээ хийн үр дүнд үндэслэн сайжруулах арга хэмжээг авч хэвшүүлэх
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх өрөө, орон тооны эмчтэй болох. • Сургуулийн орчны интернетийн хурдыг нэмэгдүүлж, утасгүй интернетийн сүлжээгээр (wi-fi) бүрэн хангах; • Сургалтад ашиглаж буй компьютерийн хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлэх. • Сүүлийн үед гарсан мэргэжлийн ном сурах бичгээр номын санг баяжуулах

4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөртэй холбоотой хийгдэж байгаа судалгаа, шинжилгээ үр дүнг тодорхой гаргаж хөтөлбөрийн зорилготой уялдуулах • Хөтөлбөрөөс хүлээж байгаа үр дүнгээ тодорхой болгох, явцыг нь төлөвлөх, тайлагнах, мөн шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг болох • Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг түвшин түвшингээр /сургалтын алба, тэнхим, багш/ нь төлөвлөж хийгдэх ажлуудыг тодорхой гаргах, мөн үнэлгээ хийх замаар сайжруулалтаа бий болгох • Төгсөгчдтэй эргэх холбоотой хамтарч тодорхой үйл ажиллагаа зохион байгуулдаг болох, цаашид сургах, мэргэшүүлэх тал дээр ажиллах • Хамтарч ажиллаж байгаа байгууллагуудтай багш оюутан солилцоо болон бусад үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам боловсруулж ажиллах, мөн төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэх • Тус сургууль нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд үр дүнд суурилсан сургалтын идэвхтэй аргуудыг ашиглаж эхлэж байгаатай холбогдон суралцагчдын сурлагын чанар, тэдгээрийн хүрэх үр дүнд шаардлагатай төсөв, зардлыг төлөвлөгөөний дагуу тодорхой тусгаж өгөх • Тодорхой төлөвлөгөөтэйгээр суралцагчдийн тоог нэмэгдүүлэх • Хөтөлбөрийг тогтвортой байлгахын тулд тодорхой асуудлуудыг /хөтөлбөрийн нэгж хичээлүүдийн суралцагчид өгөх мэдлэг ур чадвар, төгсөгчдийн загвар/ шингээсэн төлөвлөгөө гаргаж ажиллах
5	Суралцагчид чиглэсэн ажиллагаа үйл	<ul style="list-style-type: none"> • Оюутанд үзүүлэх зөвлөн туслах ажлыг зөвлөх багшаар хязгаарлахгүй төлөвлөгөөт ажил зохион байгуулан дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Сургууль дээр хичээлийн бус цагаар оюутан өөрийгөө хөгжүүлэх, цахим орчинд ажиллах боломжийг хангаж интернэт хэрэглээг шаардлага хангах түвшинд болгох

6	Багшийн ажиллагаа үйл	<ul style="list-style-type: none"> • Багш нарын судалгааны ажлын үр дүнгээр нь судалгааны болон лабораторийн туршилтын зардлыг гүйцэтгэсэн ажлын тодорхой хувьтай дүйцүүлж тус сургуулийн төсвөөс гаргадаг болох • Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг бий болгох багшлах бүрэлдэхүүн болон мэргэжлийн шаардлага хангасан мэргэжилтэнг бий болгох, мөн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, сургалтыг зохион байгуулах • Төсөл болон судалгааны ажлын захиалга өгч байгаа байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, судалгаа болон шинжилгээг хийх төсөв болон эрх зүйн орчныг сайжруулах боломжийг судлаж ажиллах
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг сайжруулж ажил олгогч, төгсөгчийн эргэх холбоог сайжруулж тэдний хөтөлбөр сайжруулахтай холбоотой өгсөн саналыг эрх үүргийн хүрээнд тодорхой хэмжээгээр хөтөлбөрт тусгах
	Шалгуур	Шаардлага
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> • Чанар удирдлага мэдээллийн албанаас жил бүр хийдэг дотоод аудитын шалгуур шаардлагад ISO 9001, ISO21001 шалгуур шаардлагыг түлхүү оруулдаг байна. Шалгуур шаардлагад байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагаас оруулан үнэлгээг хийдэг байх • Дотоод аудитаар илэрсэн зөрчлүүдэд дүгнэлт хийж санал, зөвлөмжийг үндэслэн төлөвлөгөө гарган ажиллаж сайжруулалт хийдэг байх

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн “**Ашигт малтмалын баяжуулалтын технологи**” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “**ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН**” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Үйлдвэрлэл, боловсруулалт, архитектур ба барилга байгууламж чиглэлээр хөтөлбөрийг магадлан итгэмжлэх комиссд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг . С.Долгорсүрэн

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг... Э.Нацагдорж

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Н.Уртнасан

V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

I. Багш нартай хийх уулзалт

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилл асан	Заадаг хичээл
1	Б.Алтансолонго	Багш	Магистр	4	С.МЕ223, Технологийн минералоги С.МЕ340, Ховор ба үнэт металлын хүдрийн баяжуулалт С.МЕ335, Хаягдлын аж ахуй С.МЕ327, Гравитациар баяжуулах технологи С.МЕ339, Баяжуулах үйлдвэрийн төсөл
2	Б.Номин	Багш	Магистр	6	С.МЕ207, Уурхайн технологи
3	Б.Билгүүн	Багш	Магистр	4	С.МЕ325, Ашигт малтмалыг баяжуулалтанд бэлтгэх технологи С.МЕ224, Баяжуулах үйлдвэрийн тээвэрлэлт С.МЕ337 Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагаа
4	Ш.Амгаланбаяр	Багш	Магистр	6	С.МЕ290, Уурхайн зургийн автоматжуулалт

II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Ю.Алтантүлхүүр	АМБТ-1	түүвэрлэсэн	95349165
2	Л.Ариунжаргал	АМБТ-2	түүвэрлэсэн	86140444
3	Б.Өгөөмөр	АМБТ-3	түүвэрлэсэн	90349892
4	О.Азжаргал	АМБТ-3	түүвэрлэсэн	85355253
5	О.Мөнхсолонго	АМБТ-4	түүвэрлэсэн	95345253
6	Б.Ууган-Эрдэнэ	АМБТ-4	түүвэрлэсэн	95224085

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Овог нэрс	Ажлын газар	Албан тушаал	Утас	Гарын үсэг
1	О.Баярбат	ЭҮйлдвэр ТӨҮГ, Судалгаа шинжилгээний хүрээлэн	Хяналт туршилтын тэргүүлэх мэргэжилтэн	99351506	
2	Ц.Галсүрэн	Ачих-Ихт ХХК	Ерөнхий технологич инженер	99032625	
3	Ц.Энхбаяр	Эрдмин ХХК	Үйлдвэрлэл эрхэлсэн захирал	99351154	
4	О.Оюун-Эрдэнэ	ЭҮйлдвэр ТӨҮГ, Баяжуулах үйлдвэр	Хүний нөөцийн товчооны мэргэжилтэн	99908170	
5	О.Мягмардорж	Энержи ресурс ХХК	Баяжуулах үйлдвэрийн ахлах баяжуулагч инженер	89016900	

IV. Төгсөгсөгчидтэй хийх уулзалт

№	Овог нэрс	Төгссөн он	Ажлын газар	Албан тушаал	Утас	Гарын үсэг
1	А.Халиунаа	2017	Оюу толгой ХХК	Оператор	95212255	
2	З.Оюундарь	2017	Лүүкс вүүл ХХК	Нягтлан бодогч	99368931	
3	Э.Мөнхбаяр	2020	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Насосны машинч	99401369	
4	Ч.Билэгтсайхан	2022	Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэр	Лаборант	99806212	
5	Ц.Одбаяр	2021	Оюу толгой ХХК	Оператор	95342428	
6	Б.Гоёцэцэг	2022	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Архив албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан	99650350	
7	М.Маралмаа	2021	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Хөвүүлэн баяжуулагч	99801890	

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал /албан бичгийг оруулах/



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.09.12 № 31/169
танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Шинжээчийн багийн тайланд хариу
хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын, ШУТИС-ийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн Ашигт малтмалын баяжуулалтын технологи /072404/ бакалаврын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд өгсөн шинжээчийн багийн үнэлгээний тайлан, нэгдсэн зөвлөмжтэй танилцлаа.

Боловсролын чанар, хөтөлбөрийн хөгжлийг дэмжих үүднээс шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийн дагуу хөтөлбөрийг тасралтгүй сайжруулж ажиллахаа илэрхийлж байна.

“ЭРДЭНЭТ ЦОГЦОЛБОР” ДЭЭД
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ



Д.ЗОРИГТХҮҮ

ҮІ. Үйлдвэрлэл, боловсруулалт, архитектур ба барилга байгууламжийн чиглэлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Комиссын хуралдаан (огноо) ..2024-03-20.....
Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт: Бүрэн хангасан

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжлэнэ	5 жил